**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/98/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2023 оны 01 дүгээр сарын 30 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цээням<br>Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... 10
4. АУДИТЫН ТАЙЛАН..... 14
4.1 Ерөнхий зүйл ..... 14
4.2 Материаллаг байдал ..... 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 16
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 16
Завсрын аудит хийгээгүй..... 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... 16
5.1 Төлбөрийн акт ..... 17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОБЕГ | Онцгой байдлын ерөнхий газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2023.02.10 № 2/07

танай ____________ -ны № ______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ж.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

### Аудитын гол асуудал

ОБЕГ-ын даргын 2022.05.19 өдрийн А/136 дугаар тушаалаар ОБЕГ-ын харьяа ар талын 115 дугаар ангид ашиглалтын хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоосон 180,500.0 мянган төгрөгийн Хово маркийн автомашиныг шилжүүлсэн ба Төрийн өмчийн бодлого зохицуулалтын шийдвэр гараагүй тул данснаас хасаагүй байна.

### Бусад асуудлын хэсэг

Баянхонгор аймаг дахь Онцгой байдлын хэлтэс нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилго, 12 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ОБЕГ-аас 98.5 хувиар үнэлсэн байна.

005020119

D/2023-A4 Alban toot.doc

Баянхонгор аймгийн Онцгой байдлын хэлсийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D/2023-A4 Alban toot.doc

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,086,268,481.73** | **1,076,505,029.73** |
| **33** | **АВЛАГА** | **30,000,000.00** | **30,000,000.00** |
| **33500** | **Бусад авлага** | **30,000,000.00** | **30,000,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **1,056,268,481.73** | **1,046,505,029.73** |
| **35100** | **Түүхий эд материал** | **4,385,012.27** | **2,333,327.27** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,002,652.27 | 1,904,527.27 |
| 35130 | Эм боох материал | 1,382,360.00 | 428,800.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 283,956,010.00 | 273,893,700.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **586,296,976.46** | **631,956,220.46** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,543,600.00 | 1,721,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,606,010.88 | 35,841,923.88 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,037,000.00 | 3,339,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,026,524.00 | 2,378,640.00 |
| 35460 | Хүнсний материал | 921,239.00 | 250,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 539,162,602.58 | 588,423,956.58 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 179,530,483.00 | 136,221,782.00 |
| 35600 | Мал амьтад | 2,100,000.00 | 2,100,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,122,779,764.24** | **4,063,836,356.32** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,122,779,764.24** | **4,063,836,356.32** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **3,484,058,164.24** | **3,425,114,756.32** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,219,765,375.36 | 1,283,848,359.64 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -379,602,942.27 | -512,902,104.94 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 4,064,431,516.30 | 4,248,725,943.30 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,484,500,277.07 | -1,675,832,977.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 263,777,089.00 | 299,497,176.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -216,066,154.00 | -229,825,717.56 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,431,038.98 | 31,652,455.98 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -17,177,482.06 | -20,048,378.98 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **638,721,600.00** | **638,721,600.00** |
| 39301 | Програм хангамж | 1,525,000.00 | 1,525,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,525,000.00 | -1,525,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 638,721,600.00 | 638,721,600.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,209,048,245.97** | **5,140,341,386.05** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,209,048,245.97** | **5,140,341,386.05** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **5,209,048,245.97** | **5,140,341,386.05** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,156,582,358.27 | 1,156,582,358.27 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 1,156,582,358.27 | 1,156,582,358.27 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **3,685,732,809.13** | **3,617,695,947.81** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,823,993,413.56 | 3,686,402,807.73 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 861,739,395.57 | -68,706,859.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 366,733,078.57 | 366,063,079.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,209,048,245.97** | **5,140,341,386.05** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,408,964,146.69** | **3,476,776,443.28** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,008,065,146.69** | **1,123,071,437.28** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,008,065,146.69** | **1,123,071,437.28** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **793,526,209.69** | **0** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 793,526,209.69 | 0 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,078,120,000.00 | 673,875,884.28 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 136,418,937.00 | 449,195,553.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,400,899,000.00** | **2,353,705,006.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,011,148,500.00** | **2,144,356,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,011,148,500.00 | 2,144,356,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,389,750,500.00** | **209,348,206.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,125,032,500.00 | 130,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 28,390,000.00 | 15,663,206.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 63,043,000.00 | 62,015,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 173,285,000.00 | 1,670,000.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,547,224,751.12** | **3,545,483,303.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,547,224,751.12** | **3,545,483,303.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,534,567,877.04** | **3,539,612,926.02** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,613,322,367.00** | **1,778,448,256.14** |
| 210101 | Үндсэн цалин | 1,047,656,075.00 | 1,119,459,243.14 |
| 210102 | Нэмэгдэл | 506,041,292.00 | 599,850,013.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 59,625,000.00 | 59,139,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **54,501,519.92** | **59,268,800.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,472,056.59 | 19,605,105.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,051,044.00 | 2,310,460.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,640,835.00 | 1,848,369.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 380,625.00 | 434,284.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,956,959.33 | 35,070,582.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **155,523,012.00** | **153,975,043.68** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,288,972.87 | 14,751,659.98 |
| 210302 | Түлш, халаалт | 138,512,003.13 | 134,471,087.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,722,036.00 | 4,752,296.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **176,561,374.30** | **102,893,912.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 21,506,430.00 | 12,031,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 128,934,464.30 | 75,472,414.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,920,400.00 | 4,011,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,200,080.00 | 7,271,420.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0 | 3,507,778.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,528,365,860.00** | **229,252,338.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,327,233,875.00 | 9,723,160.00 |
| 210502 | Хоол, хүнс | 162,890,305.00 | 46,432,239.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 38,241,680.00 | 173,096,939.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **197,531,825.00** | **95,553,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 154,434,500.00 | 0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 22,866,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 43,097,325.00 | 72,687,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **18,327,400.00** | **1,543,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,327,400.00 | 1,543,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **207,743,086.00** | **372,128,284.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 200,794,540.00 | 363,451,676.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 558,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,507,800.00 | 1,412,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,271,482.00 | 2,859,812.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 562,000.00 | 539,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 354,000.00 | 802,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,653,264.00 | 2,505,121.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **582,691,432.82** | **746,549,592.20** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,174,000.00 | 6,486,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 579,517,432.82 | 740,063,092.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,656,874.08** | **5,870,377.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,646,085.00** | **3,900,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,646,085.00 | 3,900,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **9,010,789.08** | **1,970,377.18** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,010,789.08 | 1,970,377.18 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **861,739,395.57** | **-68,706,859.92** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **861,739,395.57** | **-68,706,859.92** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,444,081,100.00** | **2,353,705,006.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,444,081,100.00** | **2,353,705,006.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **2,011,148,500.00** | **2,144,356,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,011,148,500.00 | 2,144,356,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **1,432,932,600.00** | **209,348,206.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,125,032,500.00 | 130,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 28,390,000.00 | 15,663,206.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 63,043,000.00 | 62,015,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 216,467,100.00 | 1,670,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,401,826,100.00** | **2,346,461,206.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,401,826,100.00** | **2,346,461,206.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,389,169,225.92** | **2,340,590,828.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,613,322,367.00** | **1,778,448,256.14** |
| 210101 | Үндсэн цалин | 1,047,656,075.00 | 1,119,459,243.14 |
| 210102 | Нэмэгдэл | 506,041,292.00 | 599,850,013.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 59,625,000.00 | 59,139,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **54,501,519.92** | **59,268,800.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,472,056.59 | 19,596,705.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,051,044.00 | 2,310,460.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,640,835.00 | 1,848,369.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 380,625.00 | 434,284.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,956,959.33 | 35,078,982.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **149,097,497.00** | **152,407,858.68** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,288,972.87 | 14,751,659.98 |
| 210302 | Түлш, халаалт | 132,086,488.13 | 132,903,902.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,722,036.00 | 4,752,296.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **67,854,500.00** | **18,257,200.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,183,300.00 | 5,894,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 53,411,300.00 | 3,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,800,400.00 | 4,011,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0 | 600,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,459,500.00 | 4,251,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **44,705,800.00** | **47,773,700.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,110,400.00 | 2,011,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 42,595,400.00 | 45,761,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,354,900.00** | **64,303,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 281,600.00 | 1,298,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,073,300.00 | 63,005,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,635,400.00** | **1,543,200.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,635,400.00 | 1,543,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,445,677,946.00** | **211,900,814.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,438,301,400.00 | 203,224,206.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 558,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,507,800.00 | 1,412,175.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,271,482.00 | 2,859,812.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 562,000.00 | 539,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 782,000.00 | 802,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,653,264.00 | 2,505,121.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,019,296.00** | **6,688,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,019,296.00 | 6,688,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,656,874.08** | **5,870,377.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,646,085.00** | **3,900,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,646,085.00 | 3,900,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **9,010,789.08** | **1,970,377.18** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,010,789.08 | 1,970,377.18 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **42,255,000.00** | **7,243,800.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **42,255,000.00** | **7,243,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **42,255,000.00** | **7,243,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **42,255,000.00** | **7,243,800.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 42,255,000.00 | 7,243,800.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-42,255,000.00** | **-7,243,800.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| **101** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** |
| **20** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.00** | **0.00** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,156,582,358.27 | 367,107,895.37 | 2,823,618,596.76 | 4,347,308,850.40 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 374,816.80 | 374,816.80 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,156,582,358.27 | 367,107,895.37 | 2,823,993,413.56 | 4,347,683,667.20 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | -374,816.80 | 0 | -374,816.80 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 861,739,395.57 | 861,739,395.57 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,156,582,358.27 | 366,733,078.57 | 3,685,732,809.13 | 5,209,048,245.97 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,156,582,358.27 | 366,733,078.57 | 3,685,732,809.13 | 5,209,048,245.97 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 669,998.60 | 669,998.60 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,156,582,358.27 | 366,733,078.57 | 3,686,402,807.73 | 5,209,718,244.57 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | -669,998.60 | 0 | -669,998.60 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -68,706,859.92 | -68,706,859.92 |
| 20 | 2022 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл | 1,156,582,358.27 | 366,063,079.97 | 3,617,695,947.81 | 5,140,341,386.05 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,144,356,800.00** | **2,142,386,422.82** | 1,970,377.18 | 99.91 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,144,356,800.00** | **2,142,386,422.82** | 1,970,377.18 | 99.91 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,139,520,200.00** | **2,138,486,422.82** | 1,033,777.18 | 99.95 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,779,089,100.00** | **1,778,448,256.14** | 640,843.86 | 99.96 |
| 210101 | Үндсэн цалин | 966,213,400.00 | 1,119,459,243.14 | -153,245,843.14 | 115.86 |
| 210102 | Нэмэгдэл | 770,404,700.00 | 599,850,013.00 | 170,554,687.00 | 77.86 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 42,471,000.00 | 59,139,000.00 | -16,668,000.00 | 139.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **59,268,800.00** | **59,268,800.00** | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,383,700.00 | 19,596,705.00 | 12,786,995.00 | 60.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,445,300.00 | 2,310,460.00 | -865,160.00 | 159.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,182,300.00 | 1,848,369.00 | -666,069.00 | 156.34 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 330,500.00 | 434,284.00 | -103,784.00 | 131.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,927,000.00 | 35,078,982.00 | -11,151,982.00 | 146.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **152,411,700.00** | **152,407,858.68** | 3,841.32 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,949,400.00 | 14,751,659.98 | 197,740.02 | 98.68 |
| 210302 | Түлш, халаалт | 132,395,100.00 | 132,903,902.70 | -508,802.70 | 100.38 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,067,200.00 | 4,752,296.00 | 314,904.00 | 93.79 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **18,257,200.00** | **18,257,200.00** | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,894,800.00 | 5,894,800.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,500,000.00 | 3,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,011,000.00 | 4,011,000.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00 | 600,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,251,400.00 | 4,251,400.00 | 0.00 | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **47,773,700.00** | **47,773,700.00** | 0.00 | 100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,011,900.00 | 2,011,900.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,761,800.00 | 45,761,800.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65,423,200.00** | **65,422,800.00** | 400.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,418,200.00 | 2,417,800.00 | 400.00 | 99.98 |
| 210604 | Урсгал засвар | 63,005,000.00 | 63,005,000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,560,400.00** | **1,543,200.00** | 17,200.00 | 98.90 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,560,400.00 | 1,543,200.00 | 17,200.00 | 98.90 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,048,100.00** | **8,676,608.00** | 371,492.00 | 95.89 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 558,000.00 | 558,000.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,412,200.00 | 1,412,175.00 | 25.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,859,900.00 | 2,859,812.00 | 88.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 539,000.00 | 539,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 802,500.00 | 802,500.00 | 0.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,876,500.00 | 2,505,121.00 | 371,379.00 | 87.09 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,688,000.00** | **6,688,000.00** | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,688,000.00 | 6,688,000.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,836,600.00** | **3,900,000.00** | 936,600.00 | 80.64 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **4,836,600.00** | **3,900,000.00** | 936,600.00 | 80.64 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,836,600.00 | 3,900,000.00 | 936,600.00 | 80.64 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,144,356,800.00** | **2,142,386,422.82** | 1,970,377.18 | 99.91 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,144,356,800.00** | **2,142,386,422.82** | 1,970,377.18 | 99.91 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,144,356,800.00 | 2,142,386,422.82 | 1,970,377.18 | 99.91 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,432,932,600.00** | **209,348,206.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,432,932,600.00** | **209,348,206.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,432,932,600.00 | 209,348,206.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,432,932,600.00 | 209,348,206.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,432,932,600.00 | 209,348,206.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,432,932,600.00 | 209348206.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,432,932,600.00 | 209,348,206.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,125,032,500.00 | 130,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,390,000.00 | 15,663,206.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 63,043,000.00 | 62,015,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 141,467,100.00 | 1,670,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь “Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Онцгой байдлын газар, урьдчилан сэргийлэх тасаг, Гал түймэр унтраах, аврах 16 дугаар анги, Гал түймэр унтраах, аврах 72 дугаар анги, Жаргалант сум дахь Эрэн хайх аврах салбар, Улсын нөөцийн 127 дугаар салбар, Баянхонгор сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Баянцагаан сум дахь эрэн хайх, аврах бүлэг, Баянговь сум дахь Эрэн хайх, аврах бүлэг зэрэг бүтэц зохион байгуулалтай, 135 орон тоо батлагдаж 121 орон тоотой ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ОБЕГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ОБЕГ-ын даргын 2016.12.15-ний өдрийн А/293 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 5,140,341.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 68,706.9 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 30,000.0 | 30,000.0 | - |
| Бараа материал | 1,056,268.5 | 1,046,505.0 | (9,763.5) |
| Үндсэн хөрөнгө | 4,122,779.8 | 4,063,836.4 | (58,943.4) |
| **Нийт хөрөнгө** | **5,209,048.2** | **5,140,341.4** | (68,706.9) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 5,209,048.2 | 5,140,341.4 | (68,706.9) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **5,209,048.2** | **5,140,341.4** | (68,706.9) |

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 30,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст барагдаагүй байна. Энэ нь 2018 онд үүссэн 2018 онд үүссэн суудлын автомашинтай холбоотой “Сод ноёд” ХХК-аас авах 30,000.0 мянган төгрөгийн авлага нь

барагдаагүй үлдэгдлээр байгаа бөгөөд тус асуудлыг Авлигатай тэмцэх газар шалгагдаж байгаа гэсэн тайлбарыг шалгагдагч байгууллагаас өгсөн.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,046,505.0 мянган төгрөг болж өмнөх оноос 9,763.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлан онд төсвийн хөрөнгөөр 259,670.6 мянга, аймгийн Онцгой комиссоос 146,767.3 мянган төгрөг, Аврагч биеийн тамир, техникийн хорооноос 915.2 мянга, Нийгмийн хамгааллын албанаас 27,600.0 мянга, НИК ХХК-аас 291.7 мянга, ОБЕГ-аас 76,404.0 мянга, ОБЕГ-ын харьяа ар талын 115 дугаар ангиас 197,104.9 мянга, ОБЕГ-ын харьяа ар талын 185 дугаар ангиас 112,5 мянга нийт 449,195.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч үйл ажиллагаандаа 557,801.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, Аймгийн засаг даргын захирамжаар төсөвт байгууллагуудад 157,320.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн, 3,507.8 мянган төгрөгийн хөрөнгийг газрын даргын 2022.06.23-ны өдрийн А/42 дугаар тушаалаар акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,063,836.4 мянган төгрөг болж 58,943.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 71832.7 мянга, ОБЕГ-аас 119,800.0 мянган төгрөгийн автомашин, Засгийн газрын 2022.11.16-ны өдрийн 497 дугаар тогтоолоор 260,000.0 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгсэл, ОБЕГ-ын харьяа ар талын 115 дугаар ангиас 20,000.0 мянган төгрөгийн станц, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.12.27-ны өдрийн 656 дугаар тогтоолоор зөвшөөрөл олгосны дагуу газрын даргын тушаалаар 2 төрлийн тээврийн хэрэгслийг ашиглалтын хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоож 195,500.0 мянга, Аймгийн ИТХ-аас 13,000.0 мянган төгрөгийн дэлгэц, Аймгийн Онцгой комиссоос 987.0 мянган төгрөгийн принтер нийт 681,119.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.12.27-ны өдрийн 706 дугаар тогтоолоор 7,795.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж 2 тээврийн хэрэгслийг ашиглалтын хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоох болсонтой холбоотой 391,005.6 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,140,341.4 мянган төгрөг болж 68,706.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 68,706.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,723,244.6 мянга, нийт зарлагыг 2,723,244.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 789,370.5 мянган төгрөгөөр бууруулж 1,933,873.5 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 2,144,356.8 мянган төгрөг болгож 210,483.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70708 хөтөлбөрийн 80801, 80802 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,144,356.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,144,356.8 улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,142,386.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй 1,970.4 мянган төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,142,386.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,970,4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70708 Гамшгаас урьдчилан сэргийлэх | 2,144,356.8 | 2,142,386.4 | 1,970.4 | 99.9 |
| 2 | 80101 үндсэн үйл ажиллагааны зардал | 2,139,520.2 | 2,138,486.4 | 1,033.8 | 99.9 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 4,836.6 | 3,900.0 | 936.6 | 80.6 |
| | Нийт дүн | 2,144,356.8 | 2,142,386.4 | 1,970.4 | 99.9 |

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030031402 тоот дансанд 209,348.2 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зарцуулсан байна.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого* */төгрөгөөр/*

| д/д | Орлогын төрөл | Авсан санхүүжилт |
|---|---|---|
| 1 | НАРАН МАНДАЛ ЭНТЕРПРАЙЗЕС ХХК хандив | 30,000,000 |
| 2 | Аймгийн ЗДТГ АЗД-ын А/38 захирамжаар малын шүлхий өвчний санхүүжилт | 9,494,500 |
| 3 | Аймгийн Засаг даргын Захирамж А/266 Онцгой комиссын үйл ажиллагаанд зардал | 3,640,000 |
| 4 | Аймгийн Засаг даргын Захирамж А/103 шатахуун | 2,528,706 |
| 5 | ОБЕГазар (Гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн томилолтын зардал) | 22,980,000 |
| 6 | ОБЕГазар санхүүжилт (Барилгын засварын зардал) | 28,200,000 |
| 7 | Цахим тендерийн үнэ | 70,000 |
| 8 | ОБЕГазар (ахмад сангийн санхүүжилт) | 2,835,000 |
| 9 | Корунд Гео ХХК хандив | 100,000,000 |
| 10 | Нисэх буудлын хамгаалалтын зардал | 1,600,000 |
| 11 | ОБЕГазар (оны тэргүүний шагнал) | 8,000,000 |
| | НИЙТ ДҮН | 209,348,206 |

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Монгол улсын шадар сайд, Баянхонгор аймгийн Засаг дарга нар нь Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх ШС-22/003 дугаартай гэрээг 2022.02.18-ны өдөр байгуулсан байна. Уг гэрээний 3 дугаар зүйлийн 3.8 дахь хэсэгт заасан “Говийн чоно” олон улсын дадлага сургуулийг зохион байгуулах” үйл ажиллагааг 2022 оны 10 сард Баянхонгор аймагт зохион байгуулсан ба Наранмандал Энтерпрайзес ХХК-аас 30,000.0 мянга, Корунд Гео ХХК-аас 100,000.0 мянган төгрөгийн хандив тусламжийн орлого орж ирснийг тухайн үйл ажиллагаанд зарцуулсан байна.
Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25 өдрийн 18/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын дарга Ж.Алтангэрэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Баянзул нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 2,146,314.8 мянган төгрөгөөс 32,194.7 мянган, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу

22,536,3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 3,224,077.4 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр тухай бүр байршуулах 2 сарын мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | 0 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | 0 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 95 | 1 | |
| | Нийт | 27 | 151 | 148 | 1 | 2 |

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 1037,339.8 мянган төгрөгийн 14 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 79,305.5 мянган төгрөгийн 9 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 65,254.9 мянган төгрөгийн 18 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 4,631.0 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 2 зөрчилд үнийн дүнгүй 2 албан шаардлага, 4,631.0 мянган зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын даргын 2022.05.30-ны өдрийн 18/170 дугаар албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

*Хүснэгт 5. Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 2 | 0 | 2 | 0 | 100 |
| Зөвлөмж | 3 | 4,631.0 | 3 | 4,631.0 | 100 |
| **Нийт дүн** | **5** | **4,631.0** | **5** | **4,631.0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1.Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 30,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст барагдаагүй байна. Энэ нь 2018 онд үүссэн 2018 онд үүссэн суудлын автомашинтай холбоотой “Сод ноёд” ХХК-аас авах 30,000.0 мянган төгрөгийн авлага нь барагдаагүй үлдэгдлээр байгаа бөгөөд тус асуудлыг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс шалгаж өмнө ажиллаж байсан нягтлан бодогчийг гэмт хэргийн шинжгүй гэж дүгнэн хэргийг хаасан байна.

2. ОБЕГ-ын даргын 2022.05.19 өдрийн А/136 дугаар тушаалаар ОБЕГ-ын харьяа ар талын 115 дугаар ангид ашиглалтын хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоосон 180,500.0 мянган төгрөгийн Хово маркийн автомашиныг шилжүүлсэн ба Төрийн өмчийн бодлого зохицуулалтын шийдвэр гараагүй тул данснаас хасаагүй байна.

3. Тус байгууллагын эзэмшлийн талбайд “Би Эйч энд ди” ХХК-ийн уурын зуухны барилга барьж, халаалтын үйл ажиллагаа явуулж буй зөрчлийг арилгах албан шаардлагыг 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байна. Уг албан шаардлагын дагуу тухайн компанийн шүүхэд өгч анхан шатны шүүх хурлаар ялсан бөгөөд тухайн компани нь давж заалдах шатны шүүхэд хандсан байна.

4. Тайлант оны 12 дугаар сард Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолыг баримтлан үр дүнгийн урамшуулал олгосон байхад “Тэргүүний хамт олон, хөдөлмөрийн аварга, тэргүүний алба хаагчийг шагнах тухай” байгууллагын даргын 2022.12.16-ны өдрийн А/81 дүгээр тушаал гарган 28,345.6 мянган төгрөгийн шагналт цалинг давхардуулан олгосон байна.

Дээрх асуудлуудыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,232.8 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 1,232.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

### 5.1 Төлбөрийн акт

1.Тус газрын даргын Б/02, Б/47, Б/82 дугаар тушаалуудаар нэр бүхий 5 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан байхад 2022.12.16-ны өдрийн А/80 дугаар тушаалаар 1,232.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гарган олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах журмыг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь**: Байгууллагын сахилгын шийтгэлтэй ажилтнуудад олгосон үр дүнгийн урамшуулал 1,232.8 мянган төгрөгийг нэр бүхий албан хаагчдаас суутган тооцож төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сахилгын шийтгэлтэй албан хаагч болон үр дүнгийн урамшуулал олгосон. | 1 | 1,232.8 | 1 | 1,232.8 | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 1,232.8 | 1 | 1,232.8 | | | | | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

ooOoo